



МОНГОЛ ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор:

Ц.Наранчимэг

Утас: 261663

Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Оюунгэрэл

Утас: 261885

Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор: Ш.Отгонбаяр

Утас: 261740

Цахим хаяг: otgonbayarsh@audit.gov.mn

Аудитын компани:

“Өлзийт Экаунт Аудит” ХХК

Утас: 70130460

Цахим хаяг: auditulziit@gmail.com

Чингэлтэй дүүрэг, 6-р хороо

Бумцэндийн гудамж, 65-р байр,

01 тоот

2018 оны 2 дугаар сар 23

1. Агуулга
2. Аудитын гэрчилгээ
3. Менежментийн захидал
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан
5. Төсвийн гүйцэтгэлийн тайлан



НЭГ. АГУУЛГА

1. Оршил
2. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
3. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
5. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
6. Дотоод хяналт
7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар
8. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
9. Шилэн дансны мэдээлэл
10. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
11. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
12. Аудитын явцад илрүүлсэн гол зөрчлүүд, гаргасан шийдлүүд
13. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
14. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
15. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
16. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
17. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
18. Зөвлөмж
19. Зөрчилгүй санал, дүгнэлт





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.23 № 06/447
танай _____ -ны № _____ -т

МОНГОЛ ГЕРМАНЫ ХАМТАРСАН
АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Н.ДОРЖДЭРЭМ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



1. Оршил

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг хийж гүйцэтгэн танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.


2. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний аудитын газрын захиалгаар “Өлзийт экаунт аудит” ХХК нь Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС-ийн аудитын байгууллагын сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэхийг зорчилж байна.



Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 2018 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хийхээр төлөвлөн “Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

“Өлзийт экаунт аудит” ХХК нь аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрөөс 2017 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн төсвийн захирагч нь Монгол улсын “Төсвийн тухай”, болон “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Боловсролын тухай”, “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт томоохон өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль боловсролын салбарын бодлого, эрх зүйн хүрээнд бүх хүч нөөцөө дайчлан ажиллаж байна.

Тус сургуулийн чиг үүрэг, үйл ажиллагаа харьцангуй тогтвортой бөгөөд 2017 онд 124 оюутан суралцаж, 65 багш, албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 95 дугаар тогтоолоор үүсгэн байгуулагдсан байна. Энэхүү сургуулийг хамтран байгуулж, хөгжүүлэхээр Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газар хоорондын нот бичгээр баталгаажуулсан байна.

Тус сургууль нь Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны харьяанд үйл ажиллагаа эрхэлдэг Төсвийн Шууд Захирагчтай төрийн байгууллага юм.

Тус сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь Монголын дээд боловсролын шинэчлэлийн түүчээ бөгөөд Азийн бүс нутагт инженер технологийн мэргэжилтний шинэ үеийг бэлтгэх төв байхаар заасан бөгөөд Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль нь өндөр зэрэглэлийн, нийгмийн хариуцлагатай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэж, нийгмийн сайн сайхны төлөө судалгаа, инновацийг хөгжүүлснээр Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой байна.

Ингэхдээ Герман улсын дээд боловсрол, шинжлэх ухааны тэргүүн туршлагыг удирдлага болгож, монголын соёлын өвд баттай суурилсан байна. Сургалт, судалгаа нь бодит хэрэглээнд чиглэсэн, аж үйлдвэрийн түншлэлд түшиглэсэн байх бөгөөд бүтээлч, шүүмжлэлтэй, нээлттэй сэтгэлгээ, манлайллыг хөхүүлэн дэмжиж ажиллах зорилт тавьсан байна.

Уул уурхайн болон боловсруулах үйлдвэрийн салбарын эрэлтэд хийсэн судалгаанд үндэслэн тус сургууль нь уул уурхайн боловсруулах инженер, механик инженер, хүрээлэн буй орчны инженер, үйлдвэрлэлийн менежмент, эдийн засагч инженер чиглэлээр бакалаврын түвшинд боловсон хүчин бэлтгэж ажиллаж байна.

Дээрх зорилтыг биелүүлэхийн тулд :

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна”, 16.4-т “Дараах албан тушаалтан төсвийн шууд захирагч байна”, 16.4.18-д “Төсвийн бусад байгууллагын дарга (захирал, эрхлэгч) тухайн байгууллагын төсвийн” гэж заасны дагуу Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн захирал төсвийн шууд захирагчийн үүрэг гүйцэтгэж байна. 2017 оны төсвийг төсвийн хуваарийн дагуу БСШУСЯ-ны Төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн үйл ажиллагааны талаар өмнөх аудит болон төлөвлөлтийн шатанд судалсан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтын аудитын баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримтлагдсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 18 горим, сорилыг гүйцэтгэв.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн найруулж өөрийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн интерактив программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг төлөвлөсөн горимын дагуу сорьсон.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн дотоод хяналтын системийг эрсдэл бага гэж тооцсон болно. Өмнөх оны аудитын зөвлөмжийн хүрээнд дотоод аудитын нэгжтэй болж хийх ажлын хөтөлбөрөө батлуулсан. Эрсдэлийг бага гэж тодорхойлсон үндэслэл нь төлөвлөлтийн шатанд авсан шалгах хуудас, санал асуулгын дүнд үндэслэсэн бөгөөд дотоод хяналтын гол анхаарах асуудал нь нягтлан бодох бүртгэл, санхүүгийн ажилтнуудын ажлын ачаалал, ур чадвар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь өөрийн үйл ажилагаанд нь хэр нийцтэй эсэхийг магадлах явдал байв.


6.Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт зардлын дүнг сонгов.

Тус сургуулийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зарлагын дүн 3,122,487.3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь 31,224.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Нийт орлого, нийт зарлага, цэвэр хөрөнгийн дүнгээс материаллаг байдал сонгоход уламжлалт эрсдэл өндөр гарч байгаа тул сонгосонгүй.

7.Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.



Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны орлогын төлөвлөгөөний биелэлтийг дараах хүснэгтээр үзүүлэв.

/Мянган төгрөгөөр/			
Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
Улсын төсвийн санхүүжилт	1,578,909.3	1,578,904.1	5.2
Үндсэн үйл ажиллагааны орлого	701,105.6	518,977.5	-182,128.0
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө		23,399.2	23,399.2
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		17,523.0	17,523.0
НИЙТ	2,280,014.9	2,138,803.8	-141,200.6

Улсын төсвийн санхүүжилт нь бүрэн орж ирсэн бөгөөд үндсэн үйл ажиллагааны орлого буюу оюутны төлбөр 182,128.0 мянган төгрөгөөр тасарсан. Энэ нь тус сургуулийн хичээлүүд англи хэл дээр ордог, сургалтын хөтөлбөр шахуу зэргээс хичээлийн жилийн явцад тэнцэхгүй, хасагдсан оюутны сургалтын төлбөрөөс болж үүссэн.

Тайлант онд нийт 5 төсөл хэрэгжиж, 40,922.2 мянган төгрөгийг зарцуулсан нь дараах байдалтай байна.

- Азийн Хөгжлийн Банкны Дээд боловсролын шинэчлэлийн төслөөс 23,399.2 мянган төгрөгийг дараах төслүүдэд зарцуулсан.
 - “Хүнд баяжигдах шинж чанартай вольфрам, молебдений хүдрээс ашигт эрдсүүдийг ялгах технологийн хувьд харьцуулсан туршилт, судалгаа, түүнийг үйлдвэрт нэвтрүүлэгт боломжийг судлах нь” судалгааны төсөл №70.
 - “Ерөнхийлсэн НЭШ-ийн тэнцвэрийн бодлогын хувьд алгоритм боловсруулалт ба хэрэглээний судалгаа” №71.
 - Оюутны санаачилга төсөл.
- Шинжлэх ухаан Технологийн сангийн суурь судалгааны төслөөс 17,523.0 мянган төгрөгийг авч дараах төслүүдэд зарцуулсан байна.
 - “Технологийн хувьд хялбар, үр ашиг өндөртэй электрохимийн аргыг хэрэглэн нүүрсэн дэх хүхрийн агуулгыг тодорхойлж, бууруулах боломжийн судалгаа”-ны төсөл №SS1-025
 - “Их үрэлтэт машины эд хөрөнгийг өөрчлөх нь” төсөл №N-A/178-27/2016

Төсвийн зарлагын гүйцэтгэлийг дараах хүснэгтээр үзүүлэв.

/Мянган төгрөгөөр/

Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт + Хэтрэлт -
Цалин хөлс, нэмэгдэл, НДШ	1,682,533.7	1,504,791.5	177,742.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	125,587.7	125,544.8	42.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,778.7	200,431.9	4,346.8
Хангамж, бараа материалын зардал	75,571.4	75,571.4	
Эд хогшил худалдан авах	15,974.6	15,974.6	
Томилолт, зочны зардал	8,662.4	8,662.4	
Бусад зардал	166,906.4	166,906.3	0.1
НИЙТ	2,280,014.9	2,097,883.0	182,131.9

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг хавсралтаар үзүүлэв.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, томилолт, зочны зардал болон бусад холбогдолтой зардлуудыг санхүүжүүлсэнтэй холбоотой.

Цалин хөдөлмөрийн хөлсний зардал хэмнэлттэй ажилласан нь сургуулийн шаардлагад нийцсэн боловсон хүчин ховор, сургуулийн хичээлийн байр алслагдмал дүүрэгт байрладагтай холбоотой батлагдсан орон тоондоо хүрч ажиллаагүй.

8. Шилэн дансны мэдээлэл

Энэ ажлын хүрээнд байгууллагын төсөв, хагас, бүтэн жилийн баталгаажсан санхүүгийн тайлан баланс, аудитын дүгнэлт, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээ, төлбөрт үйлчилгээний үнэ тариф, журам зааврыг нээлттэй ил тодоор мэдээлж ирсэн байна. Гэвч тайлант оны 2,4,9,12 дугаар саруудад мэдээг хоцроож байршуулсан байна. Мөн Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан хэсэгт хугацаа болоогүй гэсэн мэдээлэл байршуулсан байна. Энэ хэсэгт 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг мэдээлэх шаардагатай байна.

9. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 16 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 38 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Горим сорил хэрэгжүүлэх явцад тайлант оны эцэст олон нийттэй харилцах ажилтан Б.Саранг ажлаас чөлөөлж, 3 сарын цалинтай тэнцэх нөхөн олговор 4,800.0 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 41.2.2 дугаарт “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэж заасныг зөрчсөн байна.

Сургалтын төлбөрийг санхүүгийн үр дүнгийн тайланд мөнгөн сууриар бүртгэж тайлагнаж байна. 2018 оны хаврын семистрын оюутны сургалтын төлбөр 43,875.0 мянган төгрөгийг 2017 оны тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрсөн нь батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримттай, мөн Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын 2.1.3 дугаарт “Төсвийн байгууллага нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккурэл суурь дээр үндэслэн бэлтгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүний бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн дүнтэй дансанд гарсан ажил гүйлгээг, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 80 хувь, нийт зардлын 65 хувийг тус тус эзэлж байна. Тайлант онд онцлох гүйлгээ гараагүй болно.

11. Аудитын явцад илрүүлсэн гол зөрчлүүд, гаргасан шийдлүүд:


Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинж чанартай 1 алдааг олж тогтоон, материаллаг бус 1 алдаа, нийт 2 алдааг илрүүлсэн. Үүнд:

-Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй талаар:

Олон нийттэй харилцах ажилтан Б.Саранг ажлаас чөлөөлж, 3 сарын цалинтай тэнцэх нөхөн олговор 4,800.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дүгээрт “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Энэ зөрчил нь материаллагын түвшинээс доогуур байгаа тул цаашид давтагдахгүй байх талаар менежментийн захирлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.



- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар

Сургалтын төлбөрийг санхүүгийн үр дүнгийн тайланд мөнгөн сууриар бүртгэж тайлагнаж байна.

2018 оны хаврын семистрын оюутны сургалтын төлбөр 43,875.0 мянган төгрөгийг 2017 оны тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрсөн нь батлагдсан бодлогын бичиг баримттай мөн Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын 2.1.3 дугаарт “Төсвийн байгууллага нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккурэл суурь дээр үндэслэн бэлтгэнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын 2.1.3 дугаарт “Төсвийн байгууллага нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккурэл суурь дээр үндэслэн бэлтгэнэ” гэж заасны дагуу цаашид санхүүгийн тайланг аккурэл сууриар бэлтгэх талаар менежментийн захидлаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад тайлангийн алдааг санхүүгийн тайланд залруулсан бөгөөд бусад залруулаагүй алдаа зөрчил байхгүй болно.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байна.

Тус их сургууль нь Монгол, Германы хамтарсан мөн олон улсын жишигт хүрсэн сургууль болох зорилгын хүрээнд шалгуур хангасан оюутнуудад 100%, 50%-ийн тэтгэлэг олгож байна. Энэ нь улсын төсөвт орох ёстой орлогыг тэтгэлэг болгож байгаа тул зарласан тэтгэлэгийн хэмжээгээр тайлант онд Засгийн газрын хувь оролцоог нэмэгдүүлж бүртгэвэл Монгол Улсын зүгээс оруулж байгаа хувь оролцоог бүртгэж баталгаажуулна гэсэн байр суурьтай байна..

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:


Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй санхүү тайлан бүртгэлийн эрсдэлтэй асуудал гараагүй боловч Засгийн Газрын хувь оролцоог бүртгэхэд хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэхийг нягтлан үзэх асуудал үлдлээ.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 48,650.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн байна.

Олон нийттэй харилцах ажилтан Б.Саранд 4,800.0 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон.

Сургалтын төлбөрийн орлого 43,875.0 мянган төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд мөнгөн сууриар бүртгэж тайлагнасан байна.



16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан бөгөөд аудитын байгууллагаас өгсөн 3 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулж мөрдөн ажиллаж, биелэлт 100 хувь байна. Авлагын барагдалт 70 хувьтай, мөн дотоод хяналтын ажилтан авч 2018 оны хөтөлбөр батлуулан ажиллаж эхэлсэн биелэлт 100 хувь байна.

Зөвлөмжийн биелэлтийг зүйл тус бүрээр энэ тайлангийн хавсралтаар үзүүлэв.

17. Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31 өдрийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн шударга илэрхийлэгдсэн байна.

“ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ” ХХК-ИЙН:

ХОЁР ДАХЬ ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

Э.ХҮРЭЛТОГОО

АНХАН ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛСЭН:

ЗАХИРАЛ

Ц.БЯМБАЖАВ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОРЫН ТУСЛАХ





МОНГОЛ ГЕРМАНЫ ХАМТАРСАН АШИГТ МАЛТМАЛ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Агуулга:

Тэргүүлэх ач холбогдлын дарааллаар жагсаав:

Асуудал 1

Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй талаар

Асуудал 2

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар



МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидлын тайлбар, тодруулга:

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийгддэг Төрийн Аудитын Байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.



Асуудал 1: Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
--	---------------------------

Ажиглалт

Олон нийттэй харилцах ажилтан Б.Саранг ажлаас чөлөөлж, 3 сарын цалинтай тэнцэх нөхөн олговор 4,800.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас олгосон байна.

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6.4.1 дүгээр заалтыг 2018 оны тайлант хугацаанд мөрдөж ажиллах. Зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээг 6 дугаар сарын 20 нд багтаан Үндэсний Аудитын Газарт албан бичгээр хүргүүлэх.

Эрсдэлүүд

Үйлчлүүлэгчийн хариу

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дүгээрт “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах” гэж заасныг зөрчиж, санхүүгийн тайлагналын Үнэн зөв илэрхийлсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байх эрсдэл үүссэн байна

Хуулийн зөвлөх нь хүлээн зөвшөөрөхгүй байгаа.

Асуудал 2: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	---------------------------

Ажиглалт

Сургалтын төлбөрийг санхүүгийн үр дүнгийн тайланд мөнгөн сууриар бүртгэж тайлагнаж байна. 2018 оны хаврын семистрын оюутны сургалтын төлбөр 43,875.0 сая төгрөгийг 2017 оны тайлант хугацааны орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

Зөвлөмж

2018 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд оюутны сургалтын төлбөрийн орлогыг аккурэл сууриар бүртгэх.Зөвлөмжийн биелэлтийг 6 дугаар сарын 20-нд багтаан Үндэсний Аудитын Газар хүргүүлэх.

Эрсдэлүүд

Үйлчлүүлэгчийн хариу

Санхүүгийн тайлагналын үнэлгээ, толилуулга ба тодруулга батламж мэдэгдэл зөрчигдөх. Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын 2.1.3 дугаарт “Төсвийн байгууллага нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккурэл суурь дээр үндэслэн бэлтгэнэ” гэж заасныг зөрчих эрсдлүүд үүссэн байна.

Эхний хагас жилд багтаан санхүүгийн программ хангамжинд засвар оруулан зөвлөмжийн дагуу төрийн аудитын байгууллага бүртгэж хэвшинэ.

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,044,389,043.38</u>	<u>1,030,345,592.23</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,343.00	175,000.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,343.00	00.00
31110	Төгрөг	1,343.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	175,000.00
3121	Төгрөг	00.00	175,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	00.00	175,000.00
33	АВЛАГА	52,800,319.07	49,008,200.00
335	Бусад авлага	52,800,319.07	49,008,200.00
3351	Байгууллагаас авах авлага	52,800,319.07	49,008,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	991,587,381.31	981,162,392.23
351	Түүхий эд материал	859,041,925.54	870,239,482.94
35110	Тусгай зориулалттай материал	859,016,475.54	843,919,970.54
35111	Тусгай зориулалттай материал Боловсруулалт	00.00	26,244,062.40
35130	Эм боох материал	25,450.00	75,450.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	4,470,840.00
354	Хангамжийн материал	132,545,455.77	106,452,069.29
35410	Бичиг хэргийн материал	7,551,273.00	2,788,634.00
35420	Аж ахуйн материал	00.00	1,744,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,302,400.00	3,407,400.00
35470	Бусад хангамжийн материал	121,691,782.77	98,511,535.29
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>14,015,020,496.85</u>	<u>13,622,107,440.88</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,015,020,496.85	13,622,107,440.88
392	Биет хөрөнгө	14,007,163,746.76	13,601,875,140.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	12,980,886,941.00	12,982,554,541.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-702,381,375.96	-1,026,931,342.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	399,310,674.00	399,310,674.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-67,301,989.54	-120,137,568.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	768,184,836.30	994,712,706.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-322,857,241.35	-536,960,286.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	615,818,670.87	639,208,940.87
39208	Хуримтлагдсан элэгдэл	161,003,340.05	232,806,290.59
39214	Бусад үндсэн хөрөнгө	304,497,805.00	318,820,415.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-73,057,778.51	-105,434,150.06
39217	Ном	265,156,505.00	290,037,502.70
393	Биет бус хөрөнгө	7,856,750.09	20,232,299.94
39301	Програм хангамж	7,260,000.00	14,908,549.81
39303	Бусад биет бус хөрөнгө	1,265,000.00	6,245,000.00

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

39304	Хуримтлагдсан элэгдэл	-668,249.91	-921,249.87
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>15,059,409,540.23</u>	<u>14,652,453,033.11</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>38,016.00</u>	<u>1,097,731.99</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	38,016.00	1,097,731.99
413	Өглөг	38,016.00	1,097,731.99
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	38,016.00	197,731.99
4136	Бусад өглөг	00.00	900,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	900,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>15,059,409,540.23</u>	<u>14,652,453,033.11</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	15,059,371,524.23	14,651,355,301.12
512	Хуримтлагдсан үр дүн	15,059,371,524.23	14,651,355,301.12
51210	Өмнөх үеийн үр дүн	15,059,371,524.23	15,059,371,524.23
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-408,016,223.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>15,059,409,540.23</u>	<u>14,652,453,033.11</u>



АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,393,627,783.19	2,703,801,968.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	727,562,242.19	1,020,222,171.40
120	Нийтлэг татварын бус орлого	727,562,242.19	1,020,222,171.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	727,562,242.19	1,020,222,171.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	343,789,000.00	525,534,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	256,500,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	383,773,242.19	238,188,171.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,666,065,541.00	1,683,579,797.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,563,323,500.00	1,578,909,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,563,323,500.00	1,578,909,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	102,742,041.00	104,670,497.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,784,000.00	104,670,497.30
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	56,958,041.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,561,467,283.69	3,111,818,191.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,517,437,490.71	2,791,564,721.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,517,437,490.71	2,791,564,721.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,314,365,011.80	1,366,179,359.87
210101	Үндсэн цалин	1,314,365,011.80	1,366,179,359.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,259,015.43	147,582,845.09
210201	Тэтгэврийн даатгал	91,981,438.83	95,526,489.01
210202	Тэтгэмжийн даатгал	10,521,386.52	10,894,522.41
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,151,734.90	13,582,152.26
210204	Ажилгүйдлийн даатгал	2,418,585.74	2,507,243.58
210205	Эрүүл мэндийн даатгал	24,185,869.43	25,072,437.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,985,485.36	200,431,889.85
210301	Гэрэл, цахилгаан	35,462,447.40	38,785,940.63
210302	Түлш, халаалт	109,789,681.96	117,159,253.60
210303	Цэвэр, бохир ус	6,064,104.00	9,548,159.00
210304	Байрны түрээс	36,693,252.00	34,938,536.62
2104	Хангамж, бараа материалын зардал	62,020,144.38	90,225,250.08
210401	Бичиг хэрэг	16,005,925.00	11,498,856.00
210402	Тээвэр, шатахуун	13,548,400.00	15,762,044.46
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,821,909.01	16,936,373.14

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210404	Ном, хэвлэл	7,757,632.00	5,540,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	2,312,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,886,278.37	38,175,276.48
2105	Нормативт зардал	1,272,240.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,272,240.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,426,119.59	15,974,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	259,800.00	1,682,268.00
210604	Урсгал засвар	26,166,319.59	14,292,332.00
2107	Томилолт, зочны зардал	7,070,447.00	8,662,386.00
210702	Дотоод албан томилолт	7,070,447.00	8,662,386.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,548,511.86	142,924,711.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,157,684.86	122,537,075.21
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,961,707.00	14,767,536.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	562,900.00	620,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,866,220.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	677,490,515.29	819,583,679.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	878,911.11	32,563,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	66,747,205.95	91,099,426.36
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	609,864,398.23	695,920,953.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,029,792.98	320,253,469.87
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,029,792.98	320,253,469.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,029,792.98	320,253,469.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-167,839,500.50	-408,016,223.11
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-167,839,500.50	-408,016,223.11



АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр/

Данс ны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(1)	2,073,557,655.00	2,496,832,881.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	402,902,220.00	804,742,651.20
120	Нийтлэг татварын бус орлого	402,902,220.00	804,742,651.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	402,902,220.00	804,742,651.20
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	360,105,500.00	525,237,300.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	42,796,720.00	23,005,351.20
120004 4	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	256,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,670,655,435.00	1,692,090,230.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,563,323,500.00	1,578,909,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,563,323,500.00	1,578,909,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	102,742,041.00	104,670,497.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,784,000.00	104,670,497.30
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	56,958,041.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,589,894.00	8,510,433.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,589,894.00	8,510,433.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,002,105,091.00	2,412,826,128.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,002,105,091.00	2,412,826,128.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,958,075,298.02	2,092,572,659.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,318,916,888.72	1,366,051,894.97
210101	Үндсэн цалин	1,210,048,192.07	1,366,051,894.97
210104	Урамшуулал	108,868,696.65	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,275,017.24	147,250,132.46
210201	Тэтгэврийн даатгал	92,019,404.00	99,164,321.98
210202	Тэтгэмжийн даатгал	10,363,393.69	11,013,753.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,113,672.10	11,826,327.34
210204	Ажилгүйдлийн даатгал	3,596,530.26	2,084,464.53
210205	Эрүүл мэндийн даатгал	22,996,573.19	23,161,265.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	188,028,685.36	200,431,889.79
210301	Гэрэл, цахилгаан	35,462,447.40	38,785,940.63
210302	Түлш, халаалт	109,765,681.96	117,159,253.60

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210303	Цэвэр, бохир ус	6,064,104.00	9,548,159.00
210304	Байрны түрээс	36,736,452.00	34,938,536.56
2104	Хангамж, бараа материалын зардал	58,169,105.00	54,573,323.60
210401	Бичиг хэрэг	10,306,311.00	8,278,517.00
210402	Тээвэр, шатахуун	13,548,400.00	15,762,044.46
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,821,909.01	16,936,373.14
210404	Ном, хэвлэл	8,239,132.00	5,988,250.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	2,312,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,253,352.99	5,296,139.00
2105	Нормативт зардал	2,400,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,414,110.00	15,974,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	569,850.00	1,682,268.00
210604	Урсгал засвар	15,844,260.00	14,292,332.00
2107	Томилолт, зочны зардал	6,588,300.00	8,662,386.00
210702	Дотоод албан томилолт	6,588,300.00	8,662,386.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	119,015,840.70	163,872,850.21
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	106,625,013.70	143,485,214.21
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,961,707.00	14,767,536.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	562,900.00	620,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,866,220.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	106,267,351.00	135,755,582.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,604,520.00	44,699,101.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	62,662,831.00	91,056,480.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,029,792.98	320,253,469.87
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,029,792.98	320,253,469.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,029,792.98	320,253,469.87
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	71,452,564.00	84,006,752.51
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	71,404,464.00	83,833,095.51
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	71,404,464.00	83,833,095.51
2200	Дотоод эх үүсвэрээр	71,404,464.00	83,833,095.51
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	71,404,464.00	83,833,095.51
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-71,404,464.00	-83,833,095.51
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(0.00)	173657
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,343.00	1,343.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,343.00	175,000.00

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ЗГ-ын оруул сан капи тал	Дахин үнэл гээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	15,451,919,378.67	0	15,451,919,378.67
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	00.00	0	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	15,451,919,378.67	0	15,451,919,378.67
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	00.00	0	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	00.00	0	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	00.00	0	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	0	0	-224,708,353.94	0	-224,708,353.94
C08	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	00.00	0	00.00
D01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	15,059,371,524.23	0	15,059,371,524.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	00.00	0	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	15,059,371,524.23	0	15,059,371,524.23
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0	0	00.00	0	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0	0	00.00	0	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	00.00	0	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0	0	00.00	0	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	-408,016,223.11	0	-408,016,223.11
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	14,651,355,301.12	0	14,651,355,301.12



ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр /

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,343.00	(1,343.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,280,014,900.00	2,097,883,005.94	182,131,894.06	92%
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,280,014,900.00	2,097,883,005.94	182,131,894.06	92%
210	Бараа, үйлчилгээний зардал	2,280,014,900.00	2,097,883,005.94	182,131,894.06	92%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,516,118,700.00	1,357,541,461.97	158,577,238.03	90%
210101	Үндсэн цалин	1,483,618,700.00	1,357,541,461.97	126,077,238.03	92%
210104	Урамшуулал	32,500,000.00	-	32,500,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	166,415,000.00	147,250,132.46	19,164,867.54	88%
210201	Тэтгэврийн даатгал	105,770,252.00	99,164,321.98	6,605,930.02	94%
210202	Тэтгэмжийн даатгал	12,128,949.60	11,013,753.58	1,115,196.02	91%
210203	ҮОМШӨ ний даатгал	15,161,187.00	11,826,327.34	3,334,859.66	78%
210204	Ажилгүйдлийн даатгал	3,032,237.40	2,084,464.53	947,772.87	69%
210205	Эрүүл мэндийн даатгал	30,322,374.00	23,161,265.03	7,161,108.97	76%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,778,700.00	200,431,889.79	4,346,810.21	98%
210301	Гэрэл цахилгаан	35,142,300.00	38,785,940.63	(3,643,640.63)	110%
210302	Түлш, халаалт	125,277,300.00	117,159,253.60	8,118,046.40	94%
210303	Цэвэр, бохир ус	9,199,100.00	9,548,159.00	(349,059.00)	104%
210304	Байрны түрээс	35,160,000.00	34,938,536.56	221,463.44	99%
2104	Хангамж, бараа материалын зардал	75,571,400.00	75,571,400.00	-	100%
210401	Бичиг хэрэг	8,500,000.00	8,278,517.00	221,483.00	97%
210402	Тээвэр (шатахуун)	16,060,000.00	15,378,044.46	681,955.54	96%
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	17,280,000.00	16,936,373.14	343,626.86	98%
210404	Ном, хэвлэл	26,369,100.00	27,370,326.40	(1,001,226.40)	104%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,407,700.00	2,312,000.00	1,095,700.00	68%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	3,954,600.00	5,296,139.00	(1,341,539.00)	134%
2106	Эд хогшил худалдан авах	15,974,600.00	15,974,600.00	-	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,683,000.00	1,682,268.00	732.00	100%
210604	Урсгал засвар	14,291,600.00	14,292,332.00	(732.00)	100%
2107	Томилолт, зочны зардал	8,662,400.00	8,662,386.00	14.00	100%
210702	Дотоод албан томилолт	8,662,400.00	8,662,386.00	14.00	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	125,587,700.00	125,544,835.72	42,864.28	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,157,200.00	105,157,199.72	0.28	100%
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	14,810,400.00	14,767,536.00	42,864.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	620,100.00	620,100.00	-	100%

Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2201	Бараа үйлчилгээний бусад зардал	166,906,400.00	166,906,300.00	100.00	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,563,400.00	32,563,300.00	100.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	134,343,000.00	134,343,000.00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,280,014,900.00	2,098,056,662.94	181,958,237.06	92%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,578,909,300.00	1,578,904,112.94	5,187.06	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,578,909,300.00	1,578,904,112.94	5,187.06	100%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	701,105,600.00	519,152,550.00	181,953,050.00	74%
1200041	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	701,105,600.00	519,152,550.00	181,953,050.00	74%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,343.00	(1,343.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	175,000.00	(175,000.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	131.00	121.00	10.00	92%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	65.00	65.00	-	100%
620001	Удирдах ажилтан	5.00	5.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	40.00	40.00	-	100%
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00	-	100%



НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөв лөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	40,922,214.49	(40,922,214.49)	-
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	40,922,214.49	(40,922,214.49)	-
210	Бараа, үйлчилгээний зардал	-	40,922,214.49	(40,922,214.49)	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	384,000.00	(384,000.00)	-
210402	Тээвэр (шатахуун)	-	384,000.00	(384,000.00)	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	38,328,014.49	(38,328,014.49)	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	38,328,014.49	(38,328,014.49)	-
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,210,200.00	(2,210,200.00)	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,210,200.00	(2,210,200.00)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	40,922,214.49	(40,922,214.49)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	40,922,214.49	(40,922,214.49)	-
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	40,922,214.49	(40,922,214.49)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	131.00	121.00	10.00	92.37
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	65.00	65.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	5.00	5.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	40.00	40.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	65.00	65.00	-	100.00

